СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2025 I



www.sukhbaatar.nso.mn

www.1212.mn

Баруун-Урт сум
2025 он

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

2025
1 сар

Баруун-Урт сум
2025 он

ЕРӨНХИЙ ТЭМДЭГЛЭЛ

I. Товчилсон үгийн тайлал.

- Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

- 'Төл' гэсэн нь төлөвлөгөө, 'Гүйц' гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-X ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

...	Мэдээлэл байхгүй	-	Гүйцэтгэл байхгүй
0.0	Маш бага тоо	*	Урьдчилсан гүйцэтгэл
¹	Дахин		

a^x x нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь

▼▲ өөрчлөлт

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

• мянга	=1000	• $м^2$	метр квадрат
• сая	$=10^6$	• $км^2$	километр квадрат
• тэрбум	$=10^9$	• $м^3$	метр куб
• см	сантиметр	• мл	миллилитр
• дм	дециметр	• л	литр
• м	метр	• г	грамм
• км	километр	• кг	килограмм
• мян.	мянга	• цн	центнер
• %	хувь	• т	тонн
• кВт.ц	киловатт цаг	• ш	ширхэг
• ккал	килокалори		

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл 3

Үндсэн үзүүлэлтүүд 5

I Хүн ам 6

II Хөдөлмөр 8

III Нийгмийн халамж 10

IV Эрүүл мэнд 11

V Гэмт хэрэг 14

VI Мөнгө, банк 16

VII Орон нутгийн төсөв 18

VIII Үнэ 19

IX Хөдөө аж ахуй 24

X Аж үйлдвэр 27

XI Барилга 31

Хавсралт хүснэгтийн жагсаалт 33

Хавсралт хүснэгтүүд 34

БҮЛЭГ	ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:
Үндсэн үзүүлэлтүүд /Хүснэгт/	Э.Анхцэцэг
I Хүн ам	С.Мөнхбаяр
II Хөдөлмөр	Э.Анхцэцэг
III Нийгмийн халамж	С.Мөнхбаяр
IV Эрүүл мэнд	С.Мөнхбаяр
V Гэмт хэрэг	Б.Сумъяа
VI Мөнгө, Банк	Б.Сумъяа
VII Орон нутгийн төсөв	С.Мөнхбаяр
VIII.а Хэрэглээний үнэ	Б.Сумъяа
VIII.б Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	О.Ундрах
IX Хөдөө аж ахуй	О.Ундрах
X Аж үйлдвэр	Э.Анхцэцэг
XI Барилга	С.Мөнхбаяр

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН: Хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Анхцэцэг

ХЯНАСАН: Хэлтсийн дарга Т.Эрдэнэбат

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 I	2024 I	2025 I
Төрсөн хүүхэд	хүн	105 32.9	100 -4.8	89 -11.0
Нялхасын эндэгдэл	хүн	-	1	-
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	245 -56.7	322 31.4	211 -34.5
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	73 -97.4	52 -28.8	65 25.0
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	49 -29.0	50 2.0	80 60.0
Хэрэгт холбогсод	хүн	14 -75.0	22 46.7	15 -31.8
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	103.3 1.8	100.8 -2.5	101.6 .0.8
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	135.0 15.1	145.6 7.8	173.0 18.8
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	197.8 5.4	239.5 21.1	309.6 29.3
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	3.3 -76.6	14.4 4.4**	5.0 -65.4
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	1.3 -86.9	4.9 3.8**	4.0 -18.3
Том малын зүй бус хорогдол	тол	26 948 85.0**	151 330 5.6**	483 -99.7
Тэмээ	тол	11	9 -18.2	-
Адуу	тол	1 280 85.3**	4 254 3.3**	14 -99.7
Үхэр	тол	1 990 71.1**	11 704 5.9**	27 -99.8
Хонь	тол	11 449 92.3**	74 087 6.5**	215 -99.7
Ямаа	тол	12 218 81.5**	61 276 5.0**	227 -99.6
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	13.3 52.9	25.7 93.2	18.4 -28.2
Борлуулсан бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	32.0 7.6**	30.0 -6.3	32.6 8.9

Тайлбар: ** дахин

ХҮН АМ, жил бүрийн 1 дүгээр сард



Төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар буурчээ.

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээллээр 2025 оны 1 дүгээр сард 89 эх амаржиж, 89 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 11 (11.0%)-аар, төрсөн хүүхэд 11 (11.0%)-аар тус тус буурчээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн 1 дүгээр сард



1000 хүнд ногдох төрөлт өмнөх оноос 0.2 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн 1 дүгээр сард



2025 оны эхний 1 сард нас баралт 23 болж, өмнөх оноос 12 (34.3%)-аар буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 1.3, нас баралт 0.3, ердийн цэвэр өсөлт 1.0 байна.

1000 хүнд ногдох нас баралт өмнөх оноос 0.2 нэгж хувиар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ХӨДӨЛМӨР, бүртгэлтэй ажил хайгч иргэд

2025 оны 1 дүгээр сар



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх сараас 9.8 хувиар буурчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2025 оны 1 дүгээр сарын эцэст 211 болсны 54 (25.6%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 111 (34.5%) хүнээр буурсан байна.

2025 оны 1 дүгээр сарын байдлаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт 143 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 68 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн 1 сарын байдлаар



Ажилгүй иргэдийн 137 (64.9%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1 (0.5%) нь магистр, доктор, 44 (20.9%) нь бакалавр, 4 (1.9%) нь тусгай мэргэжлийн дунд, 7 (3.3%) нь мэргэжлийн анхан шат, 71 (33.6%) нь бүрэн дунд, 53 (25.1%) нь суурь, 26 (12.3%) нь бага, 5 (2.4%) боловсролгүй хүмүүс байна.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшнээр, 1 дүгээр сард



Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээ

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 12 (1.8%) хүнээр буурчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2025 оны 1 дүгээр сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 1.4 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 42 (3.0%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 0.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.1 (25.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2025 оны 1 дүгээр сард 1.5 мянган хүн хамрагдсаны 81.8 хувь нь асаргааны тэтгэмжид, 18.2 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид нийт 1.2 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оноос 0.9 (41.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сард

Үзүүлэлт	2023 I		2024 I		2025 I		Өөрчлөлт	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Дүн	Хувь
Бүгд	**7 830**	**767.3**	**20 773**	**2 102.4**	**6 908**	**1 240.6**	**- 861.8**	**- 41.0**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	3 636	552.6	3 510	865.7	3 639	1 072.4	206.7	23.9
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 350	379.3	1 387	463.1	1 429	583.1	120.0	25.9
Нийгмийн халамжийн тэтгэмж	1 324	162.4	1 441	394.7	1 540	481.4	86.7	22.0
Нийгмийн халамжийн үйлчилгээ	-	-	-	-	-	-	-	-
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	962	10.9	682	7.9	670	7.9	0.0	0.2
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	-	-	5 690	731.9	-	-	- 731.9	-
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	65	10.2	4 670	54.2	47	6.4	- 47.8	- 88.2
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	1	0.1	4	0.7	-	-	- 0.7	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	276	22.5	287	26.1	254	16.5	- 9.6	- 36.8
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	3 852	181.9	3 289	161.0	2 968	145.4	- 15.6	- 9.7
Насны хишиг	-	-	3 323	262.9	-	-	- 262.9	-

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 670 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 12 (1.8%) хүнээр буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

Халамжаас хөдөлмөрт гэсэн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд Асгат, Наран, Сүхбаатар, Халзан, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян сумд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдахаа байсан.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

ЭРҮҮЛ МЭНД, жил бүрийн 1 дүгээр сард

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид

2024 I 1 726

2025 I 1 908

10.5%

Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид

2024 I 52

2025 I 65

25.0%

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2024 I 1

2025 I -

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2024 I 1

2025 I 1

2025 оны 1 дүгээр сарын байдлаар эхийн эндэгдэл гараагүй байна.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2025 оны 1 дүгээр сард 89 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 11 (11.0%) эхээр буурсан байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 85 (95.5%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан, 5 (5.6%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн 1 дүгээр сард

Үзүүлэлт	2023 I	2024 I	2025 I	2025 I / 2024 I
	тоо			хувь
Амаржсан эх	105	100	89	-11.0
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	101	98	88	-10.2
Гэрийн төрөлт	1	-	-	-
Амьд төрсөн хүүхэд	105	100	89	-11.0
1 цагийн дотор хөхөө амалсан хүүхэд	102	93	85	-8.6
төрөлхийн гажигтай төрсөн	-	1	1	-
2500 граммаас доош жинтэй төрсөн	1	4	5	25.0
Амьгүй төрсөн хүүхэд	-	-	1	-
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 хүнд нийт төрөлтөд ногдох/	-	-	11.2	-

2025 оны 1 дүгээр сард нас баралтын 23 тохиолдол бүртгэгдсэний 2 (8.7%) нь осол гэмтлийн улмаас, 10 (11.2%) нь хорт хавдрын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн 1 дүгээр сард

Үзүүлэлт	2023 I	2024 I	2025 I	2025 I / 2024 I
	тоо			хувь
Нас баралт	25	35	23	-34.3
Эмнэлгийн нас баралт	2	4	5	25.0
Эхийн эндэгдэл	-	1	-	-
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	2	7	2	-71.4
Хорт хавдрын өвчлөл нас баралт	11	10	10	-
0-1 насны эндэгдэл	-	1	-	-
1-5 хүртэлх насны эндэгдэл	1	1	1	-

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2025 оны 1 дүгээр сард 65 болж, өмнөх оны мөн үеэс 13 (25.0%)-аар өссөн байна.

Харин салхинцэцэгээр 14 (77.8%)-аар, трихомониаз 4 (3.0 дахин), заг хүйтнээр өвчлөгчид 11 (6.5 дахин)-аар, тэмбүү 4 (4.0 дахин)- нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сараар

Халдварт өвчин	2023 I	2024 I	2025 I	Өсөлт	
	хүн			тоо	хувь
Бүгд	**73**	**52**	**65**	**13**	**25.0**
Вируст гепатит	-	-	-	-	-
Цусан суулга	1	2	1	- 1	-50.0
Гахайн хавдар	-	-	-	-	-
Бруцеллёз	-	-	-	-	-
Салхинцэцэг	22	18	32	14	77.8
Энтервируст халдвар	-	16	-	- 16	-
Улаан эсэргэнэ	-	-	-	-	-
Ecoli-оор/ A04.4/	-	1	-	- 1	-
Ёлом	1	-	-	-	-
Салмонеллт	-	3	-	- 3	-
Гар хөл амны өвчин	29	2	3	- 1	50.0
Тархины феомикоз буглаа	-	-	-	-	-
Хачигт	-	-	-	-	-
Сүрьеэ	7	6	6	0	-
Тэмбүү	3	-	4	4	-
Заг	6	2	13	11	6.5 [1]
Трихоминиаз	4	2	6	4	3.0 [1]
Ковид-19	-	-	-	-	-

Аймгийн хэмжээнд 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 27.2 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 4.4 (19.1%) мянган хүнээр өсөж, 1.9 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 4.8 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1.6 (50.3%) мянган хүнээр өсжээ.

Түргэн тусламжийн дуудлага 1.4 мянган удаа гарсны 0.2 (14.3%) мянга нь алсын дуудлага байгаа нь өмнөх оны мөн үеэс 274 (60.2%) удаагийн дуудлагаар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ГЭМТ ХЭРЭГ, 2025 оны 1 дүгээр сард

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2024 I	2025 I	
50	80	37.5% ↑

Хөнгөн хэрэг
53

Хүнд хэрэг
27

Илрүүлэлтийн хувь
12.4%

Гэмт хэргийн улмаас

Гэмтсэн хүн
10

Нас барсан хүн
7

Хохирол сая төг
545.6

Гэмт хэрэг үйлдэгсэд

Бүлгээр
0

Согтуугаар
13

Ял шийтгэгдэж байсан
2

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 30 (37.5%)-аар өссөн байна.

2025 оны 1 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 10 хүн гэмтэж бэртсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 545.6 сая төгрөгийн хохирол учирсны 12.4 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 15 хүн холбогдон сэжиглэгдсэний 13 (86.7%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ. 2025 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 4 хүн эрүүлжүүлэгдсэн байна. Шүүхийн шийдвэрээр 4 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 10.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 22.4 нэгжээр буурсан байна.

Зураг 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

МӨНГӨ, ЗЭЭЛ, 2025 оны 1 дүгээр сарын эцэст

Мөнгө, зээл

Нийт зээлдэгчийн тоо

2024 I **34 634**

2025 I **36 705**

Зээл 2025 I

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл **309.6** тэрбум төгрөг

1.9 тэрбум төгрөг Анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл

1.5 тэрбум төгрөг Чанаргүй зээл

Нийт **173.0** тэрбум төгрөг

Хугацаатай **149.7** тэрбум төгрөг

Хугацаагүй **23.3** тэрбум төгрөг

Салбар нэгжийн тоо **35**

ATM-ны тоо **34**

Ажилтнуудын тоо **175**

Карт эзэмшигчийн тоо **58 944**

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 2025 оны 1 дүгээр сарын эцэст 1.5 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.5 хувийг эзэлж байна.

2025 оны 1 дүгээр сарын эцэст Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 309.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 1.7 (0.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 70.1 (29.3%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 173.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 2.5 (1.4%) тэрбум төгрөгөөр буурсан бол, өмнөх оны мөн үеэс 27.4 (18.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт хадгаламжийн 84.4% нь хугацаатай, 15.6 % нь хугацаагүй хадгаламж байна.

Зураг 6. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 65.3 хувиар буурчээ.

Аймгийн төсвийн орлого 2025 оны 1 дүгээр сард 5.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 9.4 (65.3%) тэрбум төгрөгөөр, төсвийн зарлага санхүүжилт 4.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.9 (18.3%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 7. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төгрөг



Аймгийн нийт төсвийн 62.5 хувийг орон нутгийн төсвийн орлого, 37.5 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулсан аймгийн төсвийн мэдээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, бүлгээр, хувиар, 2025 оны 1 дүгээр сард



Тайлбар: Өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 1 дүгээр сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 8.5 хувь, өмнөх сараас 1.6 хувиар өссөн байна.

ЗУРАГ 8. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 1 дүгээр сар өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 6.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 27.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 8.0 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 7.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.1 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 26.2 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 52.5 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 8.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 1 дүгээр сард өмнөх сараас 1.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 2.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 5.6 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ 52.5 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 5. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2025 оны 1 дүгээр сард

Бараа үйлчилгээний бүлэг	2025 I / 2024 I	2025 I / 2024 XII
	хувь	
Ерөнхий индекс	**8.5**	**1.6**
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	6.5	2.6
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	-0.8	0.2
Хувцас, бөс бараа, гутал	27.1	2.8
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	8.0	0.6
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	7.5	-0.1
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	1.1	-0.9
Тээвэр	-3.0	0.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.9	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	4.5	-1.9
Боловсролын үйлчилгээ	0.0	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	26.2	5.6
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	52.5	52.5
Бусад бараа, үйлчилгээ	8.2	1.9

ЗУРАГ 9. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2025 оны 1 дүгээр сард өмнөх сараас 10.6 хувиар өсөхөд хонь, ямааны махны үнэ дунджаар 16.5 хувь, үхрийн махны үнэ дунджаар 13.8 хувь, адууны махны үнэ дунджаар 16.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд нас гүйцсэн малаас хязаалан гунан үхрийн үнэ хамгийн өндөр буюу 1.9 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2025 оны 1 дүгээр сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад атны үнэ 1.2 сая төгрөг болж, 12.5 мянган төгрөгөөр буурч, соёолон үрээний үнэ 1.0 сая төгрөг болж, 107.8 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 1.9 сая төгрөг болж, 439.3 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 259.2 мянган төгрөг болж, 69.7 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 167.5 мянган төгрөг болж, 43.2 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 10. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 1 дүгээр сард, мянган төгрөг



Хязаалан гунан үхрийн үнэ 2025 оны 1 дүгээр сард Түмэнцогт суманд хамгийн их буюу 2.8 сая төгрөг, Онгон суманд хамгийн бага буюу 1.0 сая төгрөг байна.

ЗУРАГ 11. ХЯЗААЛАН ГУНАН ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2025 оны 1 дүгээр сард, мян.төг



Хивэгний үнэ 2025 оны 1 дүгээр сард 33.3 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 714.0 (2.1%) төгрөгөөр, боодолтой өвсний дундаж үнэ 7.4 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 9.4 (56.0%) мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРА Г 12. БООДОЛТОЙ ӨВС, ХИВЭГНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 1 дүгээр сард



Ойлголт, тодорхойлолт:

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Тооцох аргачлал: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, аймгийн худалдааны цэг, ченжүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

МАЛ АЖ АХУЙ

ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ
жил бүрийн 1 дүгээр сард



АЮУЛТ ҮЗЭГДЭЛЭЭР ХОРОГДСОН ТОМ МАЛ,
малын төрлөөр, 2025 оны 1 дүгээр сард

2025 оны 1 дүгээр сард 483 толгой том мал хорогдлоо.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2025 оны 1 дүгээр сарын байдлаар оны эхний малын 0.02 хувь буюу 483 толгой мал хорогдоод байна. Нийт хорогдлыг төрлөөр нь авч үзвэл адуу 14 толгой, үхэр 27 толгой, хонь 215 толгой, ямаа 227 толгой мал тус тус хорогдсон байна.

ХҮСНЭГТ 6. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, жил бүрийн 1 дүгээр сард

Малын төрөл	Хорогдсон том мал			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2023 I	2024 I	2025 I	2023 I	2024 I	2025 I
	толгой			хувь		
Бүгд	**26 948**	**151 330**	**483**	**0.6**	**3.9**	**0.0**
Тэмээ	11	9	-	0.1	0.1	-
Адуу	1 280	4 254	14	0.3	1.2	0.0
Үхэр	1 990	11 704	27	0.6	3.9	0.0
Хонь	11 449	74 087	215	0.5	3.7	0.0
Ямаа	12 218	61 276	227	0.8	5.3	0.0

Нийт хорогдсон малын 44.5 хувийг хонь, 47.0 хувийг ямаа эзэлж байна.

ЗУРАГ 13. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, жил бүрийн 1 дүгээр сард, мянган толгой



Нийт хорогдлыг сумдаар авч үзвэл Сүхбаатар сум 66 (13.7%) толгой, Түмэнцогт сум 94 (19.5.%) толгой, Уулбаян сум 156 (32.3%) толгой, Баруун-Урт сум 167 (34.5%) толгой мал тус тус хорогдсон байна.

ЗУРАГ 14. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, жил бүрийн 1 дүгээр сард, төрлөөр



2025 оны 1 дүгээр сарын байдлаар 8 толгой хээлтүүлэгч, 94 толгой хээлтэгч, 381 толгой таваарын мал хорогдоод байна.

Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, жил бүрийн 1 дүгээр сар

Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг



Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг

Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 37.0 хувиар буурлаа.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 16.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.9 (32.5%) тэрбум төгрөгөөр буурлаа. Үүнд уул уурхай олборлолт 6.1 (29.2%) тэрбум төгрөг, боловсруулах аж үйлдвэр 1.9 (94.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, сая төгрөг



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 14.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.1 (29.2%) тэрбум төгрөгөөр буурахад нүүрсний олборлолт 7.1 (79.2%) тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 1.2 (12.2%) тэрбум төгрөгөөр буурсан нь тус тус голлон нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хайлуур жонш, хайлуур жоншны баяжмал 1.9 хувиас 2.4 дахин өсжээ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт талх, бялуу, цэвэр ус зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 20.7 хувиас 50.0 хувь хүртэл өссөн байна.

ХҮСНЭГТ 6. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2024 I	2025* I	2025* I / 2024 I
		тоо		хувь
Уул уурхай, олборлох аж үйлдвэр				
Хүрэн нүүрс	мян.т	142.4	37.9	-73.4
Цайрын баяжмал	мян.т	6.0	5.3	-12.8
Хайлуур жонш	мян.т	0.9	2.2	2.4 [1]
Хайлуур жоншны баяжмал	мян.т	1.4	2.7	92.9
Боловсруулах аж үйлдвэр				
Талх	т	10.3	14.8	43.7
Нарийн боов	т	4.4	2.8	-36.4
Хэвийн боов	т	8.6	0.7	-91.9
Бялуу	т	0.2	0.3	50.0
Хэрчсэн гурил	т	0.1	0.1	0.0
Малын мах	т	224.0	-	-
Цэвэр ус	мян.л	60.0	72.4	20.7
Бууз, банш	т	2.1	-	-

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2025 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 30.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.4 (5.0%) тэрбум төгрөгөөр өслөө.

ХҮСНЭГТ 7. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

Салбар	2024 I	2025*		2025* I / 2024 I
		I	Гадаад	
	сая.төгрөг			хувь
Нийт дүн	**28 562.0**	**30 001.6**	**27 750.5**	**5.0**
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	24 862.8	28 137.4	27 750.5	13.2
Боловсруулах аж үйлдвэр	1 990.5	135.1	-	- 93.2
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	555.2	505.7	-	- 8.9
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1 153.5	1 223.4	-	6.1

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 3.3 (13.2%) тэрбум төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 15.3 (3.1 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 16. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, сая төгрөг

Гадаад зах зээлд 2025 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 27.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 27.8 тэрбум нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт байна.

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Тайлбар: Хувираа үйлдвэрлэл эрхлэгч иргэн болон ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Статистикийн хэлтэс, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал; Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал;

БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ,
2024 онд



Барилга угсралт, их засварын ажил өмнөх оны мөн үеэс 30.2 (37.4%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Барилгын байгууллагууд 2024 онд нийт 50.5 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 8.4(16.7%) тэрбум төгрөг нь аймгийн барилгын байгууллага, 42.0(83.3%) тэрбум төгрөг нь гадны барилгын байгууллагууд хийж гүйцэтгэсэн байна.

ЗУРАГ 17. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, сая төгрөг



СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

II. ХӨДӨЛМӨР
II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар
II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар, боловсрол, насны бүлгээр
II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар
II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар
II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, сумаар
II.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, сумаар

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ
III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

IV ЭРҮҮЛ МЭНД
IV.1 ЭРҮҮЛ МЭНД
IV.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар
IV.3 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

V ГЭМТ ХЭРЭГ
V.1 БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ
V.2 БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ, сумаар
V.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИД
V.4 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИД, сумаар

VI МӨНГӨ, БАНК
VI.1 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст

VII ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
VII.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО
VII.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА
VII.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар
VII.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар

VIII ҮНЭ
VIII.а.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС
VIII.а.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны дундаж үнэ
VIII.б МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сумаар, сараар

IX ХӨДӨӨ АЖ АХУЙ
IX1 ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, сумаар

X АЖ ҮЙЛДВЭР
X.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар
X.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар
X.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар
X.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар

X.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр
X.6 ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ, сая төгрөг
X.7 ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр

XI БАРИЛГА

XI.1 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ
XI.2 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, барилгын төрлөөр
XI.3 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, сумаар

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2023		2024		2025	2025 I / 2024 I
	I	XII	I	XII	I	
	тоо					хувь
Нийт дүн	**245**	**302**	**322**	**234**	**211**	**- 34.5**
Асгат	1	2	2	12	11	5.5 [1]
Баяндэлгэр	2	8	7	1	1	- 85.7
Дарьганга	1	3	2	2	2	-
Мөнххаан	2	83	71	21	21	- 70.4
Наран	10	4	3	5	5	66.7
Онгон	5	2	2	2	4	2.0 [1]
Сүхбаатар	19	7	7	1	3	- 57.1
Түвшинширээ	68	3	3	15	17	5.7 [1]
Түмэнцогт	1	2	4	16	19	4.8 [1]
Уулбаян	8	26	26	2	2	- 92.3
Халзан	-	-	-	8	9	-
Эрдэнэцагаан	3	33	31	-	-	-
Баруун-Урт	125	129	164	149	117	- 28.7

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
	тоо															
Нийт дүн	**211**	**54**	**-**	**26**	**4**	**7**	**71**	**53**	**26**	**5**	**12**	**54**	**71**	**49**	**21**	**4**
Асгат	11	2	-	5	1	-	-	4	1	-	1	1	2	4	3	-
Баяндэлгэр	1	-	-	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-	-
Дарьганга	2	-	-	2	-	-	-	-	-	-	-	-	-	1	1	-
Мөнххаан	21	11	-	1	1	-	3	12	3	1	-	3	9	7	2	-
Наран	5	1	-	1	-	-	2	2	-	-	-	1	2	2	-	-
Онгон	4	1	-	1	-	-	2	1	-	-	-	-	3	1	-	-
Сүхбаатар	3	1	-	-	-	1	-	1	1	-	-	1	2	-	-	-
Түвшинширээ	17	2	-	1	-	1	-	7	8	-	1	5	4	6	1	-
Түмэнцогт	19	7	1	3	-	1	9	-	3	2	1	3	5	5	4	1
Уулбаян	2	-	-	1	-	-	-	1	-	-	-	1	1	-	-	-
Халзан	9	1	-	2	-	-	6	1	-	-	-	4	1	2	1	1
Эрдэнэцагаан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баруун-Урт	117	28	-	26	2	4	49	24	10	2	9	34	42	21	9	2

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2023		2024		2025	2025 I / 2024 I
	I	I-XII	I	I-XII	I	
	тоо					хувь
Нийт дүн	**220**	**1 870**	**97**	**1 874**	**143**	**47.4**
Асгат	1	70	3	159	5	66.7
Баяндэлгэр	1	33	-	62	-	-
Дарьганга	2	96	2	138	4	2.0 [1]
Мөнххаан	2	96	16	87	16	-
Наран	13	76	2	79	2	-
Онгон	-	135	-	85	2	-
Сүхбаатар	26	106	1	51	3	3.0 [1]
Түвшинширээ	60	184	-	165	2	-
Түмэнцогт	-	44	2	76	5	2.5 [1]
Уулбаян	7	88	-	32	-	-
Халзан	-	31	2	26	3	-6.1
Эрдэнэцагаан	5	171	13	72	13	-
Баруун-Урт	103	740	56	842	88	57.1

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

Сум	2023		2024		2025	2025 I / 2024 I
	I	I-XII	I	I-XII	I	
	тоо					хувь
Нийт дүн	**2**	**764**	**57**	**1 022**	**68**	**19.3**
Асгат	1	62	2	120	4	2.0 [1]
Баяндэлгэр	-	22	-	60	-	-
Дарьганга	-	73	2	133	3	50.0
Мөнххаан	-	9	24	79	24	-
Наран	-	35	2	55	2	-
Онгон	-	97	-	83	-	-
Сүхбаатар	-	43	1	4	1	-
Түвшинширээ	-	48	-	126	-	-
Түмэнцогт	-	32	-	51	-	-
Уулбаян	-	44	-	21	-	-
Халзан	-	31	2	18	2	-
Эрдэнэцагаан	-	114	15	41	15	-
Баруун-Урт	1	154	9	231	17	88.9

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, сумаар

	2022 I				2023 I				2024 I				2025 I			
	Бүгд	Үүнээс			Бүгд	Үүнээс			Бүгд	Үүнээс			Бүгд	Үүнээс		
		Байнгын	Түр	Улирал		Байнгын	Түр	Улирал		Байнгын	Түр	Улирал		Байнгын	Түр	Улирал
	тоо															
Нийт дүн	**3**	**3**	**-**	**-**	**-**	**-**	**-**	**-**	**11**	**11**	**-**	**-**	**20**	**2**	**2**	**16**
Асгат	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	2	-	2	-
Наран	2	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	-	-	-	-	-	-	-	-	11	11	-	-	-	-	-	-
Баруун-Урт	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	18	2	-	16

II.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, сумаар

Сум	2025 I		Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар		
	Бүгд	Эмэгтэй	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа
	тоо				
Нийт дүн	**20**	**4**	**18**	**1**	**1**
Асгат	2	1	-	1	1
Баруун-Урт	18	3	18	-	-

III. НИЙГМИЙН ХАЛАМЖ

III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2023 I		2024 I		2025 I		Өөрчлөлт	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Дүн	Хувь
Бүгд	**7 830**	**767.3**	**20 773**	**2 102.4**	**6 908**	**1 240.6**	**- 861.8**	**- 41.0**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	**3 636**	**552.6**	**3 510**	**865.7**	**3 639**	**1 072.4**	**206.7**	**23.9**
Нийгмийн халамжийн тэтгэвэр	**1 350**	**379.3**	**1 387**	**463.1**	**1 429**	**583.1**	**120.0**	**25.9**
Нийгмийн халамжийн тэтгэмж	**1 324**	**162.4**	**1 441**	**394.7**	**1 540**	**481.4**	**86.7**	**22.0**
Асаргааны тэтгэмж	**994**	**94.0**	**1 110**	**317.4**	**1 259**	**383.3**	**65.8**	**20.7**
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	**177**	**15.5**	189	53.9	227	70.8	17.0	31.5
